



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.06.24 № 39

Цэргийн албан хаагчийн эрхийн
хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг" гэж, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Монгол Улсын иргэн 18-25 насны эрэгтэйчүүдийг хугацаат цэргийн албанд татна." гэж тус тус заасны дагуу залуус хуулиар хүлээсэн иргэний үндсэн үүргээ биелүүлж байна. Энэхүү үүргээ биелүүлж байгаа хугацаанд хугацаат цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндийг хохироохгүй байх, цэргийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийг дээдлэн аливаа дарамт, хүчирхийллээс ангид байлгах зэрэг нь төрийн үүрэг юм.

Гэвч сүүлийн жилүүдэд хугацаат цэргийн алба хаагчид дарамт хүчирхийлэлд өртөх, эрүүл мэндээрээ хохирох, цаашлаад амь насаа алдах тохиолдлууд давтагдсаар байгаа нь хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд үүнтэй холбогдуулан цэргийн байгууллагын дотоод хяналт, хариуцлагын тогтолцоо, хүний эрхийн баталгаа хангагдаж буй эсэхэд бодитой үнэлгээ хийх шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн хугацаат цэргийн алба хаагчийн эрхийн хэрэгжилттэй холбогдуулан дараах асуулгыг Танд тавьж байна.

1. Сүүлийн 10 жилийн хугацаанд хугацаат цэргийн алба хааж байх үедээ амь насаа алдсан, эрүүл мэндээрээ хохирсон, хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчлэн алдсан алба хаагчдын тоон мэдээлэл, цэргийн ангийн байршлын нарийвчилсан мэдээлэл;

2. Дээрх тохиолдол бүрийн шалтгааны талаарх мэдээлэл /өвчлөл, осол, дүрмийн бус харьцаа, хүчирхийлэл, амиа хорлолт, бусад шалтгаан/;

3. Сүүлийн 10 жилийн хугацаанд хугацаат цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын мөрөөр хяналт, шалгалт явуулж холбогдох албан тушаалтан, салбарын сайдад хуульд заасан ямар арга хэмжээ авсан талаар мэдээлэл;

4. Хугацаат цэргийн алба хаах хугацаандаа амь насаа алдсан, эрүүл мэндээрээ ноцтой хохирсон, хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчлэн алдсан алба хаагч, тэдгээрийн гэр бүлээс ирсэн өргөдөл, гомдлын тоо болон түүний ангилал, шийдвэрлэлт, мөн олгосон нөхөн олговор, бусад дэмжлэг үзүүлсэн талаарх мэдээлэл;

Цаашид цэргийн ангиудад хугацаат цэргийн албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн, шинээр нэвтрүүлэх бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээлэл зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Х.БААСАНЖАРГАЛ

2020000113